



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2017 оны 08 сарын 15 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Сургалтын төлбөрийн нэг кредитийн
үнэлгээ тогтоох тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.4 дугаар заалт, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.6 дугаар заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. ШУТИС-ийн 2017-2018 оны хичээлийн жилийн бакалаврын сургалтын нэг кредитийн үнэлгээг өмнөх хичээлийн жилийн сургалтын төлбөрийг нэмэгдүүлэхгүйгээр хавсралтын дагуу мөрдсүгэй.
2. Магистрантурын сургалтын нэг кредитийн үнэлгээг бакалаврын сургалтын батлагдсан нэг кредитийн үнэлгээг 1.5 дахин нэмэгдүүлж тогтоосугай.
3. Докторантурын сургалтын нэг кредитийн үнэлгээг бакалаврын сургалтын батлагдсан нэг кредитийн үнэлгээг 2.0 дахин нэмэгдүүлж тогтоосугай.
4. ШУТИС-д хэрэгжүүлж байгаа гадаадын их, дээд сургуулиудтай хамтарсан хөтөлбөрийн гадаад хэл дээр заагдаж байгаа хичээлийн нэг кредитийн үнэлгээг бакалаврын сургалтын батлагдсан нэг кредитийн үнэлгээг 2.0 дахин нэмэгдүүлж тогтоосугай.
5. ШУТИС-ийн бүрэлдэхүүн Шинжлэх ухаан технологийн ахлах сургууль, Коосен загварын технологийн дээд сургуулийн 2017-2018 оны хичээлийн жилийн сургалтын төлбөрийг өмнөх оноос нэмэгдүүлэхгүйгээр 3,000,000 (гурван сая) төгрөгөөр тогтоосугай.
6. Сургалтын төлбөрийг дээд боловсролын салбарт баримталж буй бодлоготой нийцүүлэн тогтоосонтой холбогдуулан 2018 оны улсын болон нийслэлийн төсвийн төсөлд шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг тусган батлуулах талаар идэвх санаачлагатай ажиллахыг сургуулийн удирдлагад үүрэг болгосугай.

ДАРГА

Н.БЭГЗ

